

**ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ ХХК-ИЙН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, “СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ-2050” КОМПАНИЙН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БАРИМТ БИЧИГ, “ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР-2050”, ХҮНИЙ НӨӨЦИЙН СТРАТЕГИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

**2023.10.12**

**Нэг. Хяналт-шинжилгээний ажлын зорилго**

Тавантолгой төмөр зам ХХК-ийн 2023 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, “Стратеги төлөвлөгөө-2050” компанийн урт хугацааны хөгжлийн баримт бичиг, “Төмөр замын тээврийн хөгжлийн хөтөлбөр-2050”, Хүний нөөцийн стратегийн бодлогын баримт бичиг, Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөсөн арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2, 6.3 заалтыг баримталсан.

**Хоёр. Танилцуулга**

**2.1. ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ ХХК-ИЙН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

/Дэлгэрэнгүй тайланг хавсралт 1-д, хэрэгжилтийг хүснэгт 1-д үзүүлэв./

**Хүснэгт 1**

| Нийт заалт | Үүнээс |     |     |     |     | Биелэлтийн хувь |
|------------|--------|-----|-----|-----|-----|-----------------|
|            | 100%   | 90% | 70% | 50% | 30% |                 |
| 38         | 15     | 10  | 12  | 1   | -   | 86.05%          |

“Тавантолгой төмөр зам” ХХК 2023 онд 38 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлан, Зам, тээврийн хөгжлийн сайдаар хянуулан, хэрэгжүүлж байна. Төлөвлөгөөний хэрэгжилт энэ оны III улирлын байдлаар 86,05%-тай “Тодорхой үр дүнд хүрсэн” гэсэн үнэлгээ өгч байна.

**1.Төлөвлөгөөнд тусгагдсан энэ онд хэрэгжүүлэх 38 арга хэмжээнээс 15 нь бүрэн хэрэгжиж,хэрэгжих шатанд 22 арга хэмжээ, зорилтот түвшинд бүрэн хүрээгүй 1 арга хэмжээ байна. Үүнд:**

**“Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 50 хувийн үнэлгээтэй 1 арга хэмжээ:**

I. Арга хэмжээ: 1.1. Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Цогтцэций чиглэлд 5.0 сая.тн /2,4/ сая.тн ачаа тээвэрлэнэ. /Хариуцах нэгж-Тээврийн удирдлагын газар/

**Зорилтот түвшин:** III улирал: Гүйцэтгэл 70 хувьд хүргэнэ.

**Хэрэгжилт:** 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар нийт 1,181,782.54 тонн ачаа тээвэрлэж эхний 3 улирлын байдлаар төлөвлөгөөний биелэлт 23.63 хувийн биелэлттэй байна. Тээвэрлэлтийн чиглэлээр нь авч үзвэл Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд 358,508.63 тонн ачаа тээвэрлэж 11,71 хувь, Тавантолгой-Цогтцэций чиглэлд 823,273.91 тонн ачаа тээвэрлэж, тус чиглэлийн төлөвлөгөөний биелэлт 42,47 хувь байна.

**Хэрэгжээгүй шалтгаан:** Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан зүтгүүрийн нийлүүлэлт хийгдээгүй, “ТНАЛТ” төсөл ашиглалтад ороогүй, хил холболт хийгдээгүй зэрэг шалтгааны улмаас төлөвлөгөөний биелэлт хангагдаагүй, мөн компанийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө анх боловсруулахдаа төлөвлөсөн /2,4 сая.тн/ хэмжээнд хүртэл тээвэрлэх төлөвлөлт өөрчлөгдсөн;

**Дүгнэлт зөвлөмж:**

1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа “Стратеги төлөвлөгөө-2050” хөтөлбөрийг хэрэгжүүлэх дунд хугацааны “Стратеги төлөвлөгөө-2030” хөтөлбөрийг боловсруулж батлуулах;

2. Газар, хэлтэс, алба тус бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг Стратеги төлөвлөгөө-2030” хөтөлбөрт уялдуулан боловсруулах.

**2.2. ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ ХХК-ИЙН “СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ-2050” ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ**

/Дэлгэрэнгүй тайланг хавсралт 2-д, хэрэгжилтийг хүснэгт 2-д үзүүлэв./

**Хүснэгт 2**

| Нийт заалт | Үүнээс |     |     |     |     |                          |                     | Биелэлтийн хувь |
|------------|--------|-----|-----|-----|-----|--------------------------|---------------------|-----------------|
|            | 100%   | 90% | 70% | 50% | 30% | Хамаа<br>рахгүй<br>заалт | Хугацаа<br>болоогүй |                 |
| 46         | 9      | 9   | 24  | 2   | -   | 1                        | 1                   | 79,31%          |

Төлөвлөгөөнд тусгагдсан энэ онд хэрэгжүүлэх 46 арга хэмжээнээс 9 нь бүрэн хэрэгжиж, 32 арга хэмжээ хэрэгжих шатандаа, 2 арга хэмжээ нь зорилтот түвшинд бүрэн хүрээгүй байна. Үүнд:

**“Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 50 хувийн үнэлгээтэй 2 арга хэмжээ байна.**

1. Хөтөлбөрийн 2.4-т Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан холболтын төмөр замын төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, археологи, түүх угсаатан, ус зүй, палеонтологийн судалгаа хийх ажлын даалгавар боловсруулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах; **/Хариуцах нэгж- Төсөл хөгжлийн газар 50%/**

**Хэрэгжилт:** Археологийн хайгуул судалгааны ажлын дүгнэлт, Палеонтологийн хайгуул судалгааны ажлын дүгнэлт, Угсаатны зүйн авран хамгаалах хайгуул судалгааны ажлын дүгнэлтүүд гарсан ба тус дүгнэлтээр төслийн талбайд археологи, палеонтологи, угсаатны зүйн олдворууд илрээгүй тул төслийг үргэлжлүүлэхэд татгалзах зүйлгүй гэсэн дүгнэлт гарсан“Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын төсөл”-ийн Байгаль орчны төлөв байдлын тайланг “Эхопланет” ХХК боловсруулсан ба тайланг 2023 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр ирүүлсэн. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хүрээнд тус төсөлд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргуулах хүсэлтийг эрх бүхий байгууллагад буюу БОАЖЯ-нд хүргүүлсэн. Төлөвлөсөн ажлын гүйцэтгэлийн явц 50%-тай үргэлжилж байна.

**Хэрэгжээгүй шалтгаан:** Ажлын зохион байгуулалт, төлөвлөлт буруугаас

2. Хөтөлбөрийн 2.6-д Магадлагдсан зураг төслийн дагуу барилгын ажил эхлүүлэхэд шаардлагатай тогтоол, тушаал, зөвшөөрөл авах, барилгын бэлтгэл ажлыг хангах, гэрээ байгуулах; **Хариуцах нэгж:** Төсөл хөгжлийн газар

**Хэрэгжилт:** Нарийвчилсан зураг төсөл боловсруулах (Зам) ажлыг 2023.09.15-10.31;Барилга, Механик болон Цахилгаан тоног төхөөрөмжийн инженерийн ажлын зураг төслийн ажлыг 2023.10.01-11.21; Нарийвчилсан зураг төсөл батлуулах (магадлуулах) хугацааг 2023.11.21-11.24;

**Хэрэгжээгүй шалтгаан:** Хугацаа төлөвлөлт буруу хийгдсэн.

### **Дүгнэлт, зөвлөмж:**

Тус хөтөлбөр нийт 9 зорилтын хүрээнд 46 арга хэмжээ хэрэгжиж байгаагаас хэрэгжилт 78,2%-тай “Тодорхой үр дүнд хүрсэн” зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай” гэсэн үнэлгээтэй байна.

Цаашид:

1. “Стратеги төлөвлөгөө-2050” хөтөлбөрийг хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөө боловсруулж батлуулах;

2. “Стратеги төлөвлөгөө-2050” хөтөлбөрийн анх батлагдсан хувилбар болох Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021.02.18-ны өдрийн 02 дугаар тогтоолоор батлагдсан хөтөлбөрийн Тэргүүлэх чиглэлийн 2-т заасан Чойбалсан-Хөөт-Бичигтийн чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалт нь Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн хуралдааны 116 дугаар тогтоолоор дээрх чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэх тусгай зориулалтын компани байгуулах асуудлыг “Монголын төмөр зам” ТӨХК-д даалгасан байна. Харин одоогийн гаргаж байгаа хэрэгжилтээр Тэргүүлэх чиглэлийн 2-т “Хил холболтын төмөр зам”-ын хүрээнд хийгдэх арга хэмжээ орсон байгааг Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор өөрчлөлт оруулан батлуулах;

3. Нийт газар, хэлтэс, нэгжүүд бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнахдаа ЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журамд заасны дагуу тайлагна;

4. Дээрх 50% хэрэгжсэн 2 арга хэмжээний гүйцэтгэлийг зорилтод түвшинд хүргэж ажиллах

### **2.3. “ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР-2050” ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ**

/Дэлгэрэнгүй тайланг хавсралт 3-д, хэрэгжилтийг хүснэгт 3-д үзүүлэв./

| Нийт заалт | Үүнээс |     |     |     |     |                  | Хүснэгт 3<br>Биелэлтийн хувь |
|------------|--------|-----|-----|-----|-----|------------------|------------------------------|
|            | 100%   | 90% | 70% | 50% | 30% | Хугацаа болоогүй |                              |
| 37         | 11     | 8   | 9   | 3   | 4   | 2                | 77,7%                        |

Тус хөтөлбөрт тусгагдсан 6 зорилтын хүрээнд 37 арга хэмжээ хэрэгжиж байгаагаас 11 нь бүрэн хэрэгжиж, хэрэгжих шатанд 17 арга хэмжээ, 7 арга хэмжээ нь зорилтот түвшинд хүрээгүй байна.

**“Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 30%-50% хувийн үнэлгээтэй 7 арга хэмжээ**

1.Хөтөлбөрийн 3.1.1-д Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн нүүрс тээвэрлэсэн ачааны хэмжээ; /Хариуцах нэгж-Тээврийн удирдлагын газар 30%/

**Хэрэгжилт:** 2022 онд 5 сая тонн ачаа тээвэрлэхээр төлөвлөсөн. 2022 оны 07-р сарын 09-ний өдөр тээвэрлэлтийн үйл ажиллагаа эхэлснээс хойш 2022 он дуустал Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд 123,477.0 цэвэр тонн ачаа тээвэрлэсэн. 2022 онд

тээвэрлэх ачааны хэмжээг 1.5 сая тонн ачаа тээвэрлэхээр төлөвлөсөн. Тус хөтөлбөрт 2023 онд 10 сая тонн ачаа тээвэрлэхээр төлөвлөсөн. Ачаа тээвэрлэх хэмжээг ЗТХЯ-аас өгсөн шийдвэр, компанийн ачаа тээврийн 2023 оны төлөвлөгөөнд батлагдсанаар Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд 3 сая тонн ачаа тээвэрлэхээр төлөвлөсөн. 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд 422,189.37 тонн ачаа тээвэрлэж 13,79 хувьтай.

**Хэрэгжээгүй шалтгаан:** Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан зүтгүүрийн нийлүүлэлт хийгдээгүй, "ТНАЛТ" төсөл ашиглалтад ороогүй, хил холболт хийгдээгүй зэрэг шалтгааны улмаас төлөвлөгөөний биелэлт хангагдаагүй.

2.Хөтөлбөрийн 3.1.3-д Ачааны хэмжээний өсөлттэй уялдсан хөдлөх бүрэлдэхүүний хэрэгцээ; **/Хариуцах нэгж-Тээврийн удирдлагын газар 50%/**

**Хэрэгжилт:** Хөтөлбөрт 10 сая.тонн ачаа тээвэрлэхэд хэрэгцээт вагоны парк 508 ширхэг, хэрэгцээт гол замын зүтгүүр 12 ширхэг, сэлгээний зүтгүүр 2 ширхэг, хоногт ачих ачаа тээврийн хэмжээ 30 мянган тонн байхаар төлөвлөсөн. Өнөөдрийн байдлаар 811 вагон паркийг бүрдүүлсэн. 2024 оны 10 дугаар сарын 11-ний өдөр "Тавантолгой төмөр зам" ХХК болон "Бодь интернэшнл" ХХК-иудын төлөөллүүд "Зүтгүүр ашиглуулах гэрээ"-ний талаар уулзалт зохион байгуулсан. 2023 оны 10-р сарын 16-ны өдрөөр гэрээг эцэслэж, 2023 оны 10-р сарын 23-ны өдрөөс эхлэн ТЭЗЗАС серийн 2 ширхэг зүтгүүрийг Тавантолгой-Гашуунсухайтын төмөр замын тээврийн үйл ажиллагаанд ашиглаж эхлэхээр төлөвлөж байна..

**Хэрэгжээгүй шалтгаан:** Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан зүтгүүрийн нийлүүлэлт хийгдээгүй, "ТНАЛТ" төсөл ашиглалтад ороогүй, хил холболт хийгдээгүй зэрэг шалтгааны улмаас төлөвлөгөөний биелэлт хангагдаагүй.

3.Хөтөлбөрийн 3.1.7-д Бусад ачаа тээвэрлэлт; **/Хариуцах нэгж- Тээврийн удирдлагын газар-30%/**

**Хэрэгжилт:** Тус хөтөлбөрт 2023 онд 240 мянган тонн нефтийн бүтээгдэхүүн тээвэрлэхээр төлөвлөсөн. Үүнээс 42,536 тонн нефтийн бүтээгдэхүүн тээвэрлэсэн байна. 2023 оны 4 дүгээр сард Тавантолгой өртөөг аюултай ачаанд нээлттэй өртөөгөөр зарлуулсан.

**Хэрэгжээгүй шалтгаан:** Тээвэрлэлтийн үйл ажиллагаа хөтөлбөрт тусгасан хугацаанаас хойшилсон.

4.Хөтөлбөрийн 3.1.8-д Тээвэр зохион байгуулалт; **/Хариуцах нэгж-Тээврийн удирдлагын газар 30%/**

**Хэрэгжилт:** Тавантолгой өртөөнөөс БНХАУ-ын Ганцмод өртөө хүртэл нүүрс тээвэрлэлтийг өөрийн хөдлөх бүрэлдэхүүнээр хоногт 1-р үе шатанд 4 хос галт тэрэг аялуулахаар төлөвлөсөн. ТТ-ГС чиглэлд төмөр замаар тээвэрлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулж Гашуунсухайт "ШАТ"-д хүргэн автомашинд шилжүүлэн ачиж хил гаргаж байна. Тээврийг гол замын түрээсийн нэг илчит тэрэг, сэлгээний нэг илчит тэрэг, 811 вагоноор зохион байгуулж, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн ханган ажиллаж байна.

**Хэрэгжээгүй шалтгаан:** Хил холболтын төмөр замын ажил, ерөнхий гүйцэтгэгчээс зүтгүүрийн нийлүүлэлт хугацаандаа хийгдээгүй.

5.Хөтөлбөрийн 3.2.1-д Зүтгүүрийн аж ахуйн хөгжил; **/Хариуцах нэгж- Тээврийн удирдлагын газар-50%**

**Хэрэгжилт:** Зүтгүүр ашиглалтын чиглэлээр 2023 оны 09 дүгээр сарын байдлаар 879 галт тэрэг аялал хийж 1,031,630 тонн бохир ачаа, 625,193 тонн цэвэр ачаа ачиж, 898,054 км гүйлтэд 395,697 литр түлш зарцуулсан. Зүтгүүрийн засвар, үйлчилгээний чиглэлээр 165 удаа ТО-2 техник үйлчилгээ хийгдсэн. Үүнд: М62УММ-006-д 16 удаа, М62УММ-013-д 28 удаа, М62УММ-015-д 13 удаа, М62УММ-001-д 108 удаа техник үйлчилгээг хийж зүтгүүрийн найдвартай үйл ажиллагааг хангаж ажилласан байна. Зүтгүүр

нийлүүлэгдэхтэй холбогдуулан бэлтгэл ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллаж байна.

**Хэрэгжээгүй шалтгаан:** Ерөнхий гүйцэтгэгчээс зүтгүүрийн нийлүүлэлт хугацаандаа хийгдээгүй.

6.Хөтөлбөрийн 3.3.1-д Тээвэрлэлтийн үйл явцын удирдлага, ачаа тээвэрлэлтийн үйлчилгээнд мэдээллийн болон автоматжуулсан системийг нэвтрүүлэх, хөгжүүлэх; **/Хариуцах нэгж- Статистик систем хөгжүүлэлтийн хэлтэс 30%/**

**Хэрэгжилт:** УБТЗ руу программ хангамжийг хийлгэх, хөгжүүлэхтэй холбоотой үнийн саналыг батлагдсан төсөв /600 сая төгрөг/-т багтаан, ажлын даалгаврын хүрээнд хийх боломжтой эсэх талаар 2023 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 1/1840 дугаар бүхий албан бичиг хүргүүлсэн “УБТЗ” ХНН-ээс хариу ирүүлээгүй байна. ЗТХЯ, СССХ-ийн зүгээс тээврийн программ хангамжийг бусад /“МТЗ” ТӨХК, “ТТЗ” ХХК/ байгууллагуудад нэвтрүүлэхтэй холбоотой асуудлаар “УБТЗ” ХНН-тэй харилцан зөвшилцөж, нэгдсэн чиглэлийг өгөхөөр болсон.

**Хэрэгжээгүй шалтгаан:** Программ хангамжийг хийлгэх, хөгжүүлэхтэй холбоотой “УБТЗ” ХНН-ээс ирүүлсэн үнийн санал нь манай компанийн бизнес төлөвлөгөөнд батлагдсан зардлаас хэтэрсэн дүнтэй байгаагаас шалтгаалан удаашралтай байна.

7.Хөтөлбөрийн 3.5.1-д Мэргэжлийн боловсон хүчнийг бүрдүүлэх; **/Хариуцах нэгж: Хүний нөөц, сургалтын хэлтэс-50%/**

**Хэрэгжилт:** 2021-2022 онд “Төмөр замын дээд сургууль”, “Төмөр замын политехникийн коллеж”, “ШУТИС”, “МТСургууль”, Өмнөговь аймгийн Даланзадгад сумын ЗДТГ, аймгийн МСҮТ, Цогтцэций сумын МСҮТ зэрэг боловсролын байгууллагуудтай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулан шинэ төгсөгчдийг урилгаар болон сурлагын дүн, хувь хүний төлөвшил, ур чадварыг харгалзан сонгон шалгаруулж, хүний нөөцийн бүрдүүлэлтийг зохион байгуулан ажиллаж байна. Дасан зохицох хөтөлбөр батлуулан чиглүүлэх сургалтыг зохион байгуулж байна.

**Хэрэгжээгүй шалтгаан:** Ажлын зохион байгуулалт, уялдаа холбоо муу.

#### **Дүгнэлт, зөвлөмж:**

Тус хөтөлбөр нь 2023 оны эхний 9 сарын байдлаар нийт 6 зорилтын хүрээнд 37 арга хэмжээ хэрэгжиж байгаагаас Нийт хэрэгжилт **77,7 хувьтай** бөгөөд **“Тодорхой үр дүнд хүрсэн”** зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай” гэсэн үнэлгээтэй байна.

Цаашид:

1. Тус хөтөлбөрийн ерөнхий агуулга, утга санаа нь “Стратеги төлөвлөгөө-2050” хөтөлбөртэй давхцсан байх тул дунд хугацааны “Төмөр замын тээврийн хөгжлийн хөтөлбөр 2030”- хөтөлбөрийг боловсруулан батлуулах;

2. Хөтөлбөрт тусгагдсан 50-аас доош үнэлгээтэй цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан зүтгүүрийн нийлүүлэлт хийгдээгүй, “ТНАЛТ” төсөл ашиглалтад ороогүй, хил холболт хийгдээгүй зэрэг бусад шалтгааны улмаас төлөвлөгөөний биелэлт хангалтгүй ажлуудыг төсөл хэрэгжүүлэгчээс яаралтай дуусгах ажлыг зохион байгуулах;

3. Төмөр замын тээврийн багц программ хангамжийг хийлгэх, хөгжүүлэхтэй холбоотой ажил 30 хувьтай удаашралтай байгаа арга хэмжээг эрчимжүүлэх;

4. Газар, хэлтэс, нэгжүүд бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнахдаа товч, тодорхой байх, мөн Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу тайлагнах;

#### **2.4. ХҮНИЙ НӨӨЦИЙН СТРАТЕГИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ**

/Дэлгэрэнгүй тайланг хавсралт 4-д, хэрэгжилтийг хүснэгт 4-д үзүүлэв/

Хүснэгт 4

| Нийт арга хэмжээ | Үүнээс |     |     |     |     |   |                  | Биелэлтийн хувь |
|------------------|--------|-----|-----|-----|-----|---|------------------|-----------------|
|                  | 100%   | 90% | 70% | 50% | 30% | 0 | Хугацаа болоогүй |                 |
| 30               | 7      | 14  | 6   | 2   | 0   | 1 | 0                | 83.66%          |

Тус хөтөлбөрт тусгагдсан 5 зорилтын хүрээнд 30 арга хэмжээ хэрэгжиж байгаагаас 7 нь бүрэн хэрэгжиж, хэрэгжих шатанд 20 арга хэмжээ, зорилтот түвшинд хүрээгүй 2, огт хэрэгжээгүй 1 арга хэмжээ байна.

**“Эрчимжүүлэх шаардлагатай” 3 арга хэмжээ байна. Үүнд:**

1. Баримт бичгийн Тэргүүлэх чиглэл-2, хэрэгжүүлэх арга хэмжээ 7-д Авьяас чадварын менежментийн бодлогыг тодорхойлох, батлуулах. /Уг арга хэмжээ 2021-2022 онд хэрэгжихээр төлөвлөгдсөн байсан. **/Хариуцах нэгж-Хүний нөөц, сургалтын хэлтэс 0%/**

**Хэрэгжилт:** Төрөөс баримтлах “Хэмнэлтийн тухай хууль” гарсантай холбоотойгоор ур чадварын модуль худалдан авах ажил хойшлогдсон. Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл 2023 оны 7-р сард дүгнэгдсэнээс хойш ахиц гараагүй үргэлжилж байна.

**Хэрэгжээгүй шалтгаан:** Зорилт арга хэмжээг хэрэгжүүлэх талаар 2 жил дараалан зохион байгуулалтын ямар нэг арга хэмжээ авч ажиллаагүй.

2. Баримт бичгийн Тэргүүлэх чиглэл-3, хэрэгжүүлэх арга хэмжээ 3-д Ажилтнуудын гүйцэтгэл, бүтээмжид суурилсан цалин хөлс, урамшууллын тогтолцоог үе шаттайгаар хэрэгжүүлэх, сайжруулах. **/Хариуцах нэгж-Хүний нөөц сургалтын хэлтэс 50%/**

**Хэрэгжилт:** Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үнэлгээний системийг боловсруулаад байна. Улмаар 2023 онд гүйцэтгэлд суурилсан цалингийн системтэй болох зорилт тавин ажиллаж байна. Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл 2023 оны 7-р сард дүгнэгдсэнээс хойш ахиц гараагүй байна.

**Хэрэгжээгүй шалтгаан:** Ажлын зохион байгуулалт хангалтгүй.

3. Баримт бичгийн Тэргүүлэх чиглэл-4 хэрэгжүүлэх арга хэмжээний 1-д Манлайллыг байгууллагын бүх төвшинд буюу хувь хүний манлайлал, багийн манлайлал, байгууллагын манлайллыг хөгжүүлэх системийг бий болгох, хэрэгжүүлэх **/Хариуцах нэгж-Хүний нөөц сургалтын хэлтэс 50%/**

**Хэрэгжилт:** Манлайлах ур чадвар олгох сургалтын хөтөлбөр боловсруулан сургалтын төлөвлөгөөнд тусгасан. 2023 оны 4-р улиралд бүх удирдах ажилтнуудыг “Манлайллын хөтөлбөр”-т суралцуулахаар ажиллаж байна.

**Хэрэгжээгүй шалтгаан:** Ажлын зохион байгуулалт хангалтгүй.

#### **Дүгнэлт, зөвлөмж:**

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн Хүний нөөцийн стратегийн баримт бичиг нь нийт 5 тэргүүлэх чиглэлийн хүрээнд 30 арга хэмжээ хэрэгжиж байгаагаас нийт хэрэгжилт **83.66%**-тай **“Тодорхой үр дүнд хүрсэн”** зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай” гэсэн үнэлгээтэй байна.

Цаашид:

1. Хүний нөөцийн стратеги, бодлого дотроос гүйцэтгэлийн менежмент, сургалт хөгжлийн үйл ажиллагаа бусад үйл ажиллагааг бодвол харьцангуй сул байна. Хүний

нөөцийн чиглэлээр хийсэн судалгаа, мэдээллийн сан, ХАБЭА-ын чиглэлээр хийсэн судалгаанууд шаардлагын түвшинд хийгдсэн хэдий ч цаашид хүний нөөцийн төлөвлөлт, хөдөлмөрийн харилцаа, сонгон шалгаруулалт, хөдөлмөрийн дотоод журам, цалин хөлсний тогтолцоог сайжруулах, боловсронгуй болгох нь зүйтэй байна.

2. Компанийн хүний нөөцийн стратегид өмнө дурьдсанчлан Хүний нөөцийн нэгдсэн бодлого, үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, ойролцоо зорилт бүхий арга хэмжээнүүдийн уялдаа холбоог анхаарахаас гадна хүний нөөцийн удирдлагын хүрээнд хийгдэж буй ажлуудыг урт хугацааны үр дүнд чиглүүлж, бодлогын баримт бичгийн зорилго, зорилтуудын нэгдмэл байдлыг баримтлаж шинэчлэн батлах.

3. Бодлогын баримт бичигт заасан олон чиглэлийн дүрэм, журам, төсөл хөтөлбөрүүд боловсруулан мөрдүүлэх зорилтуудаас, ажилтан албан хаагчдын сургалт хөгжилтэй, холбоотой дүрэм журмуудын хэрэгжилт, тэдгээрийн үр дүнг нь богино хугацаанд тогтмол үнэлж дүгнэж байхад анхаарч, тодорхой чиглэлүүдээр авах судалгаа, санал асуулгуудын асуумж, ярилцлага нэгбүрийн агуулгыг нарийн тооцож оновчтой байдлаар зохион байгуулан удирдах албан тушаалтнуудыг цаг үеийн оновчтой мэдээ, мэдээллээр хангаж шинэ стратеги баримтлан уян хатан ажиллах боломжийг бүрдүүлэх.

## 2.5. ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ, ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

/Дэлгэрэнгүй тайланг хавсралт 5-д, хэрэгжилтийг хүснэгт 5-д үзүүлэв./

Хүснэгт 5

| Нийт заалт | Үүнээс |     |     |     |     |   |                  | Биелэлтийн хувь |
|------------|--------|-----|-----|-----|-----|---|------------------|-----------------|
|            | 100%   | 90% | 70% | 50% | 30% | 0 | Хугацаа болоогүй |                 |
| 18         | 16     | 2   | -   | -   | -   | - | -                | 98%             |

Тайлант хугацаанд Хувьцаа эзэмшигчдийн хурал нийт 3 удаа хуралдан 4 асуудал хэлэлцэн 4 тогтоол шийдвэр гаргасан, Төлөөлөн Удирдах Зөвлөл нь нийт 11 удаа хуралдан 14 тогтоол, шийдвэр гаргасан бөгөөд тогтоол, шийдвэрийн биелэлт 98 хувьтай буюу “Бүрэн хэрэгжсэн” гэсэн үнэлгээтэй байна.

**1. Энэ оны эхний хагас жилд хэрэгжүүлэх 10 арга хэмжээнээс 9 нь бүрэн хэрэгжиж, 1 арга хэмжээ нь зорилтот түвшинд хүрээгүй байна. Үүнд:**

ТУЗ-ийн 2023 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн “Компанийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн тухай” буюу 07 дугаар тогтоолын хэрэгжилтыг хангах ажлын хүрээнд хийгдэж буй Үндэсний аудитын газраас Компанийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн хяналт шалгалтын албан шаардлага, залруулга, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах. /Хариуцах нэгж- Санхүү төлөвлөлтийн газар 90%/

**Хэрэгжилт:** Төлөвлөгөөний хэрэгжилт 2023 оны 09 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар санхүүгийн тайлангийн залруулга 6-100%, хууль хяналтын байгууллагад шилжүүлэх 2-100%, албан шаардлага 9-90%, зөвлөмж 15-100%, төлбөрийн акт 3-85% хувийн тус тус биелэлттэй байна.

**Хэрэгжээгүй шалтгаан:** ЭТТ компаниас авах ТНАЛТ төслийн нэмэлт санхүүжилтийн авлага тооцоо төлөгдөх эсэх нь тодорхойгүй тулган баталгаажуулах захидлаар баталгаажуагүй (150.0) сая төг

ТУЗ-ийн 2023 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн "Компанийн 2023 оны батлагдсан төсвийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай" буюу 08 дугаар тогтоолоор өөрчилөн батласан дараах төлөвлөгөөний гүйцэтгэлийг тухайн товлосон хугацаанд нь гарган ТУЗ-д танилцуулан ажиллах. Үүнд:

- Компанийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин,
- Үйл ажиллагааны зардлын төлөвлөгөө,
- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө зэрэг болно.

ТАНИЛЦСАН:


"ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ" ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Н.БУДБАЯР



ХЯНАСАН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,  
ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ ДАРГА

Н.МӨНХСҮРЭН



НЭГТГЭСЭН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,  
ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ АУДИТОР

Ц. НУГАРМАА

